

Бичсэн osaka

2015 оны 10-р сарын 13, Мягмар гариг, 07:12 - Сvvлд шинэчлэгдсэн 2015 оны 10-р сарын 13, Мягмар гариг, 08:24



Ази, Номхон далайн аюулгвй байдлын хамтын ажиллагааны зовлолийн (CSCAP) 10 дахь удаагийн нэгдсэн хуралдааныг 2015 оны 10 дугаар сарын 21-нээс 23-ны одор “Ази, Номхон далайд итгэлцэл бий болгох нь: XXI зууны аюулгвй байдлын тогтолцоо” сэдвээр Улаанбаатар хотноо зохион байгуулах гэж байна. Тус арга хэмжээг CSCAP-ийн Монгол дахь Нарийн бичгийн дарга нарын газар болох Үндэсний аюулгвй байдлын зовлолийн Стратегийн судалгааны хврээлэн (ССХ) зохион байгуулах богоод нэгдсэн хуралдаанд 20 орны 150 толоологч оролцохоор байна.

CSCAP бол бvс нутгийн аюулгвй байдлын орчин, учирч буй сорилтын талаар эрдэмтэн, судлаачдын дунд хэлэлцvvлэг орнvvлж, дvгнэлт, санал, санаачилгыг тор, засгийн холбогдох байгууллагад зовломж болгон хvргэх, аюулгвй байдлын хамтын ажиллагааг хогжvvлэх зорилго бvхий торийн бус байгууллага юм. Тус байгууллага Еврази, Америк, Австрали тивийн улсыг эгнээндээ нэгтгэж жил ирэх бvр хvрээгээ тэлж байна. Монгол Улс тус байгууллагад 1996 онд элссэн ч онгорсон хугацаанд зовхон судалгааны багт оролцсон байдаг. Энэ удаагийн хуралдааныг зохион байгуулах эрх авсан явдал нь Монгол Улс бvс нутгийн аюулгвй байдал, хамтын ажиллагаанд хувь нэмрээ оруулж буйн тод илрэл болно. Тус байгууллагын Удирдах зовлол жилд 2 удаа, харин нэгдсэн хуралдаан хоёр жилд 1 удаа болдог юм. Нэгдсэн хуралдаанд бvс нутгийн тор засгийн удирдах албан тушаалтан, элчин сайд, нэр хvндтэй эрдэмтэд оролцдог уламжлалтай.

Эдvгээ Зvvн хойд Азийн бvс нутагт их гvрнvvдийн цэрэг-улс тор, эдийн засгийн орсолдоон нэмэгдэх хандлагатай байна. Тvvнчлэн Солонгосын хойгийн байдал тогтворгвй хэвээр, Зvvн Азид газар нутгийн маргаанаас vvдсэн сорголдоон гарч болзошгвй энэ эгзэгтэй цаг вед тус байгууллагын гишvvн орнуудаас нэр хvндтэй эрдэмтэн, судлаачид ирж буй нь зов гарц, боломж бий болгох, ойлголцлыг нэмэгдvvлэх ач холбогдолтой билээ.

АЗИ, НОМХОН ДАЛАЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛИЙН НЭГДСЭН

Бичсэн osaka

2015 оны 10-р сарын 13, Мягмар гариг, 07:12 - Сvvлд шинэчлэгдсэн 2015 оны 10-р сарын 13, Мягмар гариг, 08:24

CSCAP-ийн 10 дахь удаагийн нэгдсэн хуралдаан нь 2016 онд Улаанбаатар хотноо зохион байгуулагдах АСЕМ-ийн дээд хэмжээний уулзалтын омно болж буйгаараа онцлогтой болж байна.